

**ЦАГДАН ХОРИХ БАЙРНЫ ХАРУУЛ ХАМГААЛАЛТАД
АНХААРАХ АСУУДАЛ /Цагдан хорих 461-р ангийн жишээн дээр/**

POLICE PRISON GUARD FOR PROTECTION ISSUES TO BE CONSIDERED

/On the example of police detention class 461/



Г.Сэргэлэн

*Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын
71 дүгээр тойргийн шийдвэр гүйцэтгэгч, ахмад*

Товч утга: Энэхүү илтгэлээрээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа цагдан хорих байруудын аюулгүй байдал, түүний онцлог, үйл ажиллагаанд нь тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх, харуул хамгаалалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй хүчин зүйл, анхаарах асуудлын талаар судалж санал, дүгнэлтийг дэвшүүлэн гаргасан болно.

Түлхүүр үгс: Цагдан хорих байр-хоригдогч, хоригдол-эрсдэл-аюулгүй байдал-харуул хамгаалалт.

Abstract: In this report, the security of the detention facilities under the Judiciary, its characteristics, solving the problems faced by the operation, and the factors and issues to be considered in the operation of the security guard are studied and put forward suggestions and conclusions.

Keywords: Detention facility-detainee, prisoner-risk-security-security.

Хууль гэдэг бол нийгмийн харилцааг зохицуулж буй төрийн бодлого юм. Хуулиар нь дамжуулан тухайн улсын явуулж буй бодлогыг харж, нийгмийг нь таньж мэдэрч болдог бөгөөд хүн хуулийн дор төрж, хуулийн дор амьдарч, хуулийн дор үхдэг нь жам билээ.

Нийгэм болон нийгмийн үнэт зүйл, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалахын тулд төр зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн болон үйлдсэн байж болзошгүй хэмээн сэжиглэгдэж буй этгээдүүдийн эрхийг хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэдэг бөгөөд албадлагын арга хэрэгслийн хамгийн хүнд хэлбэрийн нэг бол цагдан хорих үйл ажиллагаа юм.

Энэхүү илтгэлээрээ хорих байгууллагын үйл ажиллагааны нэг хэсэг болох цагдан хорих үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж хөндсөн төрийн албадлагын онцгой процесс болохын зэрэгцээ цагдан хорих байрны аюулгүй

байдал, түүний онцлог, аюулгүй байдлыг хангахад харуул хамгаалалтын албаны ажлын үр нөлөө, ач холбогдол, эрх зүйн зохицуулалт сэдвийн хүрээнд бичихийг зорилоо.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5 дугаар бүлгийн 5.1-д “*Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино*”¹⁸ гэж заасан байдаг

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн¹⁹ 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг уг хуульд заасан үндэслэл журмын дагуу цагдан хорьж тусгаарлах албадлагын арга хэмжээг хэрхэн ямар хугацаагаар авах тухай тодорхой тусгасан байдаг.

Цагдан хорих байранд хоригдож буй хоригдогч нар нь гэмт хэрэгт ял шийтгүүлээгүй, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт сэжиглэгдэн түр саатуулагдан шалгагдаж байгаа иргэн тул хуулиар хязгаарласнаас бусад Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээж хуульд заасны дагуу сонгуулийн үеэр сонгох эрхээ эдэлж саналаа өгч байдаг онцлог бүхий эрх зүйн субъект билээ.

Цагдан хорих байрны өдөр тутмын болон харуул хамгаалалт, аюулгүй байдлын үйл ажиллагааг Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль /1999 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 2002 оны 01 дүгээр сарын 10-ны хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан/, Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар батлагдсан “Хорих байрны дотоод журам” болон бусад эрх зүйн актуудад тулгуурлан зохион байгуулан ажиллаж байна.

“Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-иар цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах талаар олон зүйлийг хуульчлан зааж өгсөн байдаг. Тухайлбал: Хорих байрны хамгаалалт, хорих өрөөнд тавигдах шаардлага, хоригдсон этгээдийн хорих өрөөнд хуваарилах, хоригдогчийн эрх үүрэг, хоригдсон этгээдийн аюулгүй байдлыг хангах, сахилгын шийтгэл оногдуулах, галт зэвсэг болон мэх хэрэглэх, тусгай хэрэгсэл хэрэглэх, хорих байранд онцгой дэглэм тогтоох зэрэг аюулгүй байдлыг хангах гол чухал хүчин зүйлүүдийг тогтоож өгснөөрөө онцлогтой.

“Хорих байрны дотоод журам”-аар цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах, харуул хамгаалалтыг зохион байгуулалт үүрэгтэй гол субъектуудийн гүйцэтгэх эрх, үүрэг, мөн хорих байранд нэвтрэх албан тушаалтнууд, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хорих байрны хорих байранд мөрдөх цагийн хуваарь, хорих өрөөг онгойлгох, хоригдогч

¹⁸ Эрүүгийн хууль./ Шинэчилсэн найруулга.2015 он/

¹⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль./ Шинэчилсэн найруулга. 2017 он /

нарт зөвшөөрсөн болон хориглосон зан үйл зэрэг дотоод үйл ажиллагаатай холбоотой олон харилцааг зохицуулж өгсөн байдаг.

Цагдан хорих байранд хоригдож буй хоригдогч нар нь эхэн үедээ сэтгэл зүйн байдлын хувьд тогтворгүй байдаг тул тухайн хоригдогч нарт харуул хамгаалалтын тасралтгүй хяналтыг тавьж байх шаардлагатай бөгөөд одоогийн байдлаар цагдан хорих төвд нэг хамгаалалтын ажилтанд 80-110 хоригдогч ноогдож байгаа нь харуул хамгаалалтын хүч суларч гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй эрсдэлтэй байдалтай байна.

Хоригдогчдын дундаас амь, бие эрхтэндээ гэмтэл учруулах оролдлого хийж байгаа зөрчлүүдийн ихэнх хувь нь 48 цагаар саатуулагдаж байгаа хоригдогчдын дундаас гарч байгаа нь анхаарал татах зүй ёсны асуудлын нэг билээ.

Цагдан хорих байрны аюулгүй байдалд заналхийлэх гол объект бол хоригдогч, хоригдогчийн сэтгэл зүйн байдалд сөргөөр нөлөөлж буй гадаад болон дотоод хүчин зүйл байдаг тул хорих байрны аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагын үүднээс харуул хамгаалалтын албаны хүн нөөцийн бодлогыг тогтвор суурьшилтай байлгахад бодлогын шийдвэр гаргах түвшинд энэ талаар анхаарах шаардлага зүй ёсоор бий болсоор байна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан бөгөөд уг хуулийн “288.6.Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.”²⁰ гэсэн /Энэ хэсгийг 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн./ хэсгийг нэмэлтээр оруулж өгснөөр хөдөө орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан, тогтвор суурьшилтай ажиллуулах чухал шийдвэр болсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Гэхдээ Монгол Улсад ганцхан байдаг Нийслэл дэх цагдан хорих төвийн алба хаагчдыг хамруулсан бол тус төвийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг дэмжсэн чухал шийдвэр болох байлаа.

Орон нутаг дахь цагдан хорих төвүүдэд хоригдож байгаа хоригдогч нарын талаар судлахад дунджаар 30-50, багадаа 10-15 орчим хоригдогчтой байдаг бол цагдан хорих төвд 700-900 хоригдогч, хоригдол өдөр тутам хоригддог бөгөөд нэг хамгаалалтын ажилтанд оногдох хоригдогч, хоригдлын тоо нормативаар бол 25 байдаг бол тус төвийн нэг хамгаалалтын ажилтанд хамгийн багадаа 50-70 хоригдогч, ихдээ 110 хоригдогч оногддог бөгөөд энэхүү ажлын ачааллаас шалтгаалан албан хаагчдын дунд ажлаас халшрах хам шинж илэрч улмаар ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх нь сүүлийн 3 жилийн байдлаар 86, /үүнээс цалин хангамж болон ажлын ачааллаас болж чөлөөлөгдсөн 60 орчим/, өөр анги байгууллага руу 40-50 шилжих, цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй ч 20 жил ажилласан гэсэн шалтгаанаар цэргийн байнгын тэтгэвэрт

²⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он.

гарах 25 хөдөлгөөнүүд сүүлийн 2 жилд огцом өссөн нь хүний нөөцийн албаны судалгаанаас харагдаж байна.

Тухайлбал: 2020 онд 14 албан хаагч өөрийн хүсэлтээр, 2021 онд 31 албан хаагч, 2022 онд 41 албан хаагч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн бөгөөд ажилласан жилээр нь харахад 1 сараас 3 жил хүртэл хугацаагаар ажилласан албан хаагчид байна.

Мөн ээлжийн бүрэлдэхүүний албан хаагчдаас 7 хоногт 1-2 албан хаагч ажил таслах нь хэвийн үзэгдэл болоод байна.

Өнөөдрийн байдлаар тус ангийн харуул хамгаалалтын албанд хамгаалалтын ажилтны 23 орон тоо буюу бүтэн нэг ээлжийн ахлагч бүрэлдэхүүний орон тоо дутуу байна.

Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын ажилласан жилийн байдалд судалгаа хийхэд эрэгтэй албан хаагчид 80 хувийг эзэлж байна.

Тэтгэвэрт гарсан албан хаагчдын насны байдалд судалгаанаас харахад цагдан хорих төвд ажилласан ажлын дадлага туршлагатай цаашид 3-4 хүртэлх жил ажиллах боломж бүхий насны албан хаагчид байна.

Алба хаагчдын дунд хийсэн биечилсэн сурвалжилгын аргын судалгааны дүнгээс харахад хүн 5 жил нэг газраа ажилласан тохиолдолд тухайн ажил болон орчин нөхцөл, ажлын ачаалалдаа дасан зохицох чадвартай болдог бөгөөд 5 жил болох хугацаанд ажлын өндөр цалин хангамж бүхий өөр байгууллагыг сонирхох, ажлын ачааллаас шантран цалин багатай ч өөр газар ажиллах зэрэг сонголтуудыг хийдэг байна.

Сүүлийн хоёр жилийн байдлаар цагдан хорих төвд хоригдож байгаа хоригдогчдын дундаас албан хаагчдын хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, доромжилсон, дайрч довтолсон гэсэн үндэслэлээр сахилгын шийтгэл хүлээлгэсэн 2021 онд 10, 2022 онд 6, 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар 2 хоригдогч байна.

Алба хаагчдад оногдуулсан сахилгын шийтгэлийг сүүлийн 3 жилийн байдлаар судлахад хоригдогч, хоригдолтой хувийн харьцаа тогтоосон үндэслэлээр нийт 13 албан хаагч сахилгын арга хэмжээ авагдсанаас ажлаас халах сахилгын шийтгэлээр 8 алба хаагчид сахилгын арга хэмжээ авсан байна.

Гүйцэтгэх ажлын шугамаар авагдаж буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд алба хаагчдаас хориотой эд зүйл нэвтрүүлэх, ар гэртэйгээ холбоо бариулахын тулд мөнгө болон бусад эд зүйл амлах зэрэг мэдээлэл их авагддаг ба энэ нь сахилгын шийтгэлийн тодорхой хувийг эзэлдэг.

Зөвхөн эдийн засгийн баталгааны байдлаас шалтгаалан албан хаагчид ажлаас чөлөөлөгдөж байна гэвэл өрөөсгөл ойлголт бөгөөд хоригдогчдын дундаас ирж байгаа сэтгэл зүйн болон биет хэлбэрийн дарамт, дайралт, сүрдүүлэг, заналхийллээс шалтгаалан шинээр томилогдсон алба хаагчид ажлаас халшрах хандлага их байна.

Хорих байгууллагын нэгээхэн хэсэг болох цагдан хорих байрны харуул хамгаалалтын албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай дараах үндсэн шаардлагууд байна. Үүнд:

- Гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчил, учралаас урьдчилан сэргийлж хорих байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах.

- Мэргэшсэн тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх гэх мэт.

Цагдан хорих төвийн албан хаагчдын тогтвортой суурьшилтай ажиллах орчныг бүрдүүлснээр ШШГТ-хуулийн “245.2.Хорих ангийн алба хаагч биечилсэн хамгаалалт, жижүүрийн үүргийг дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ.” хэрэгжилтийг хангаж ээлжийн бүрэлдэхүүнийг 4 ээлжээр явуулах боломж харагдаж байгаа бөгөөд үүний үр дүнд алба хаагчид ар гэртээ зарцуулах цаг хугацаа нэмэгдэх, өөрийгөө хөгжүүлэх зэрэг олон талын боломж харагдаж байгаа юм.

Нийгэм, улс орны болон эрүүгийн нөхцөл байдал, хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөн зэргээс шалтгаалан хуульд тухай бүрт шинэчлэн найруулга хийснээр дотоод аюулгүй байдал хангагдах нэг чухал хүчин зүйл болохын зэрэгцээ хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд ихээхэн үр дүнтэй үйл ажиллагаа болно хэмээн дүгнэж байна.

Иймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын өмнө тулгамдаж буй гол асуудлын нэг бол алба хаагчдыг тогтвортой суурьшилтай ажиллуулах эрх зүйн орчныг тухай бүр шинэчилж байх явдал бөгөөд үүний үр дүнд хорих анги болон цагдан хорих байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа хангагдаж гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, мэргэшсэн тогтвортой суурьшилтай ажиллах албан хаагчдын нөөцийг бүрдүүлэх нь хорих байгууллагын аюулгүй байдал хангагдах үндэс суурь болно.

Дүгнэлт

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 288 дугаар зүйлийн “288.6.Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална” гэсэн хэсэгт Нийслэл дэх цагдан хорих төвийн харуул хамгаалалтын албан хаагчид хэмээн эрх зүйн зохицуулалтыг нэмэн тусгуулах саналтай байна.

Нийгмийн болон эрүүгийн нөхцөл байдлын цаг үетэй уялдуулан хуульд дээрх нэмэлт өөрчлөлтийг яаралтай нэмэлт оруулснаар үндэсний болон нийгэм, төр, иргэний аюулгүй байдлыг хангуулахын зэрэгцээ хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийн тогтвор суурьшилтай ажиллах үйл ажиллагааг сайжруулсан чухал эрх зүйн зохицуулалт болох билээ.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2017 он.

6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль./ Шинэчилсэн найруулга. 2017 он /
7. Монгол улсын Эрүүгийн хууль 2015 он
8. Гүйцэтгэх ажлын тухай хууль. 1997.12.19.
9. “ШШГБ-ын гүйцэтгэх тагнуулын ажлын заавар” 2006 он

---o0o---